



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/730  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Батсүрэнгийн Ундрахын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Батсүрэнгийн Ундрахын Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Батсүрэнгийн Ундрахын сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Батсүрэнгийн Ундрахад

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАТСҮРЭН ОВОГТОЙ УНДРАХ  
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


НЭГ: Ерөнхий зүйл

Сум орныхоо хөгжил дэвшлийн төлөө санаа бодлоо илэрхийлж ИТХ-ын шийдвэр гаргуулахын төлөө, иргэдээ төлөөлөн идэвх санаачилгатай ажиллана

ХОЁР: Үндсэн заалт

1. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмол үйл ажиллагаатай болгон хүүхдийн эрхийг хамгаалахад манлайлан ажиллана.
2. “Гэр орон сууц” хөтөлбөр санаачлан, орон гэргүй айл өрхөд дэмжлэг үзүүлэх бодлого гаргаж ажиллана.
3. Хүүхдээ сонсох өдрийн үйл ажиллагааг үр дүнд хүргэж шийдвэр гаргах түвшинд дэвшүүлж хэрэгжилтэд анхаарна.
4. Гэр бүлд зөвлөгөө өгөх төв байгуулж хүүхэд залуу үеийн хүмүүжил төлөвшилд эцэг эхийн хариуцлага оролцоог нэмэгдүүлнэ.
5. Боловсролын чанарт онцгой анхаарч удирдлага менежментийг сайжруулах өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
6. Жил бүр элсэлтийн ерөнхий шалгалтад хамгийн өндөр оноо авсан багш, сурагчийг урамшуулдаг журамтай болгоно
7. Нутгийн багшлах боловсон хүчнийг дэмжин ажиллана.
8. Эх хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулан өсөлтийн хоцрогдлыг арилгахад чиглүүлнэ.
9. Орон нутагт модны үйлдвэрлэл мужаан цех байгуулах, хөгжүүлэх зорилт тавьж ажиллана.
10. ИТХ-ын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, сумын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулдаг байхад анхаарч ажиллана.
11. Спортын салбарт холбоодыг дэмжин хамтарч ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Б.УНДРАХ/



00000001